

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилго нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд хамаарах биеийн тамир, спортын салбарын үндсэн зорилт, чиг үүрэг болох иргэд биеийн тамир, спортоор хичээллэх олон талт боломжийг бүрдүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, спортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үндэсний спортын өв соёлыг хамгаалж өвлүүлэх, шинжлэх ухаан, технологийн үр нөлөөг нэмэгдүүлж, спортын ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд оршино.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Биеийн тамир, спортын салбарын хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, салбарын статистик мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийн нэгтгэх, нэгдсэн удирдлагаар хангах, эрх зүйн дэмжлэг үзүүлэх, спортын байгууллагуудын зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох нөхцөлийг бүрдүүлэх;

Биеийн тамир, спортын салбарын удирдлагын манлайллыг хангах, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхыг сайжруулах, байгууллагын соёл төлөвшүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх;

Спортын сургалт дасгалжуулалт, спортын анагаах ухааны үйл ажиллагаанд шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, үндэсний спортын өв соёл, хэв маягийг хадгалж хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг сайжруулах, тэмцээн наадмын зохион байгуулалтыг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;

Хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэдийн бие бялдрын түвшнийг сайжруулах, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор насан туршийн боловсрол болгон хөгжүүлэх, биеийн тамирын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

Биеийн тамир, спортын салбарын санхүү, эдийн засгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн багцыг төлөвлөх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх, төсөв санхүүгийн гүйцэтгэлийг удирдах, зохицуулалтаар хангах, хэрэгжүүлэх;

Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг спортын холбоодоор гүйцэтгүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, олон улсын туршлага, арга технологийг нэвтрүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх."